



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

до 26. 07. 30 № ХЯТ/2571
танай _____-ны № _____-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Таны 2026 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 41 дугаартай асуулгын дагуу БНСУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр "10 аймгийн дулааны станц барих төсөл"-ийн хүрээнд Өвөрхангай аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын барилга угсралтын ажлын хэрэгжилт, гэрээний үүргийн биелэлт болон тус аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа хоёрдугаар хэлхээний шугам сүлжээний ажлын явцтай холбогдох мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265008023

МЭДЭЭЛЭЛ

БНСУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “10 аймгийн дулааны станц барих төсөл”-ийн талаарх ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 459 дүгээр тогтоолоор Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр төвлөрсөн дулаан хангамжгүй 10 аймгийн төвд дулааны станц барихаар шийдвэрлэсний дагуу 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Сангийн яам болон БНСУ-ын “Экспорт-Импорт” банк хооронд зээлийн гэрээг байгуулсан.

Төслийн хүрээнд Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Хэнтий аймгийн төвд 20-оос 30 Гкал/ц хүчин чадалтай 10 дулааны станцыг дагалдах дэд бүтцийн хамт барьж байгуулахаар төлөвлөсөн.

Зээлийн хэлэлцээрт “...Гэрээ гүйцэтгэгчийг БНСУ-ын компаниудын дунд өрсөлдөөнт тендер шалгаруулалтыг явуулж сонгоно.” гэж, мөн Зээлийн гэрээнд “... Нийлүүлэгч нь Бүгд Найрамдах Солонгос Улсын харьяат, эсхүл харьяалах бүртгэл хийлгэсэн хуулийн этгээд байна.” гэж заасны дагуу зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгч болон барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг “Экспорт-Импорт” банкны худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах ба гүйцэтгэгч нь БНСУ-ын аж ахуй нэгж байх нөхцөлтэй.

Үүний дагуу БНСУ-ын “Экспорт-Импорт” банкны худалдан авах ажиллагааны журмын дагуу тендерийг 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зарлаж, 2020 оны 5 дугаар сарын 06-ны өдөр нээхэд тендерт оролцохоор нэг ч компани материал ирүүлээгүйгээс тендер шалгаруулалт амжилтгүй болсон байна.

Захиалагч тендер амжилтгүй болсон шалтгааныг судалж, банк болон зөвлөх компанитай зөвшилцөн тендерийн баримт бичигт зохих өөрчлөлтийг оруулж, дахин зарлаж, тендерийг 2020 оны 8 дугаар сард нээхэд 2 компани оролцохоор материал ирүүлсэн боловч 1 оролцогч нь техникийн шаардлага хангаагүй, нөгөө оролцогч нь хэт өндөр үнийн санал буюу 79%-аар хэтэрсэн үнийн санал ирүүлсэн.

Тендерийн үнэлгээ, үр дүнг БНСУ-ын “Экспорт-Импорт” банкинд хүргүүлэхэд холбогдох журмын дагуу уг компанитай гэрээний хэлцэл хийхийг тус банкнаас мэдэгдсэн бөгөөд банкны зөвлөмж, журмын дагуу хэлцэл хийсэн боловч 2 тал зөвшилцөлд хүрээгүй тул 2020 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр тендерээс татгалзаж тендер дахин амжилтгүй болсон.

Захиалагч барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендер амжилтгүй болсон шалтгаан, дахин тендер зарлахад анхаарах асуудлуудын талаар судалж, санал дүгнэлтийг хэлэлцүүлэн, тендерийг газар зүйн байршлаар хэд хэдэн багцад хуваах саналыг 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдөр БНСУ-ын “Экспорт-Импорт” банкинд хүргүүлж, 2021 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр уг тендерийг 3 багц болгон зарлах зөвшөөрлийг банкнаас ирүүлсэн байна.

Уг зөвшөөрлийг үндэслэн тендерийг 3 багц болгон 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн зарлаж, багц тус бүрийг зохих журмын дагуу үнэлсний үр дүнд БНСУ-ын “Бьюксан инженеринг” компани бүх багц дээр шалгарч “Багц 1” (Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай) болон “Багц 3” (Говьсүмбэр, Сүхбаатар, Хэнтий) ажлын гэрээг 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдөр, “Багц 2” (Дундговь, Төв аймаг) ажлын гэрээг 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдөр тус тус

1
түлхүүр гардуулах нөхцөлтэй (ЕРС) байгуулсан ба "Бьюксан инженеринг" компанитай байгуулсан "Багц 1, 2, 3" ажлуудын гэрээний нийт дүн 110.0 сая ам.доллар байна.

Захиалагч Эрчим хүчний яам, гүйцэтгэгч "Бьюксан инженеринг" компани, санхүүжүүлэгч "Экспорт-Импорт" хооронд төслийн зураг төсөл, худалдан авалт, барилга угсралт болон ашиглалтад хүлээлгэн өгөх ажлын гүйцэтгэлийг хэмжих, тайлагнах нэгдсэн аргачлалыг тооцох журмыг хамтран баталж, төслийн хэрэгжилтийг 3 үндсэн үе шатанд хувааж, үе шат бүрт жин оноосон. Үүнд: 1. Зураг төсөл-1.5%, Худалдан авалт-75.0%, Барилга угсралтын ажил -23.5% байхаар тооцоолсон.

Энэ төсөлд тоног төхөөрөмж, бараа материалын худалдан авалт нь өндөр жинтэй буюу 75%-ийг эзэлж байгаа тул худалдан авалтын явц төслийн нийт гүйцэтгэлд хамгийн ихээр нөлөөлж байна. Энэхүү журмын дагуу хянасан гэрээ (ЕРС)-ний хэрэгжилтийн хувьд 47%-ийн гүйцэтгэлтэй байгаа бол 9 аймагт төслийн барилга угсралтын ажил эхэлсэн бөгөөд дунджаар 37% гүйцэтгэлтэй байна.

"Бьюксан инженеринг" компанийн зураг төслийн ажлын туслан гүйцэтгэгчээр "Мон-Энержи Консалт" ХХК, барилга угсралтын ажлын туслан гүйцэтгэгчээр "МЭЗ" ХХК, "Энерготех сервис" ХХК, "Энерго сервис монтаж" ХХК, "Мон-Энержи Корпораци" ХХК, "Хасумегаватт" ХХК-ууд консорциум болон тус тус ажиллаж байсан.

2026 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар тус төслийн хүрээнд хэрэгжиж байгаа Өвөрхангай аймгийн дулааны станцын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 41.93 хувийн явцтай байна.

Зээлийн ашиглалтын хувьд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт зээлийн хөрөнгөөс 62,065,398.0 ам.доллар буюу 41.7%-ийг ашигласан бөгөөд үүнээс 6,103,139.0 ам долларыг зөвлөх үйлчилгээнд, 55,900,255.0 ам.долларыг барилга угсралтын ажилд, 62,004.0 ам.долларыг банкны үйлчилгээний хураамжид тус тус зарцуулсан байна.

"10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл"-ийн хүрээнд нэг талаас захиалагч Эрчим хүчний яам, нөгөө талаас гүйцэтгэгч БНСУ-ын "Бьюксан инженеринг" компани хооронд байгуулсан дулааны станц барих түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээнүүдийн хэрэгжилтийн явцад төслийн ерөнхий гүйцэтгэгчээс дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал болон Орос-Украины асуудал зэргээс шалтгаалан бараа материал, тоног төхөөрөмжийн үнэ батлагдсан төсөвт өртгөөс нэмэгдсэний улмаас худалдан авалт хийх боломжгүй болсон тул гэрээний төсөвт өртгийг 64.0 сая ам.доллараар нэмэгдүүлэх хүсэлтийг Эрчим хүчний яаманд удаа дараа ирүүлж байсан.

Эрчим хүчний яамны зүгээс гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ нь түлхүүр гардуулах нөхцөлтэй учраас гэрээний төсөвт өртгийг нэмэгдүүлэх буюу ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх боломжгүйг тухай бүр мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь дээрх шалтгаанаар барилга угсралтын ажлыг удаашруулсан.

Эрчим хүчний яам, "KDHEC" зөвлөх компани болон гүйцэтгэгч "Бьюксан инженеринг" компанийн төлөөллүүд удаа дараа уулзалт зохион байгуулсан бөгөөд уулзалтын үеэр гүйцэтгэгч компанийн зүгээс төслийн барилга угсралтын ажлыг амжилттай дуусгаж, цаашид гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, санхүүгийн хуваарийг баталгаажуулан ирүүлэх, мөн гэрээг хэрэгжүүлэх явцад үүсэх хариуцлагыг бүрэн

1
хүлээхээ илэрхийлж, урьдчилгаа төлбөрийн баталгаа болон гүйцэтгэлийн баталгааг 2026 оны 08 дугаар сарын 31-ний өдөр хүртэл тус тус сунгаж ирүүлсэн тул яамны зүгээс төслийг бүрэн хэрэгжүүлж дуусгах зорилгоор гэрээний хугацааг 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан.

Гэтэл Төслийн ерөнхий гүйцэтгэгч "Бьюксан инженеринг" компани нь санхүүгийн хүндрэлд орж, улмаар 2025 оны 03 дугаар сарын 04-ний өдөр БНСУ-ын Сөүл хотын Дампуурлын хэргийн шүүхэд дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргаж дампуурлын хэрэг үүсгэсэн байна. Эрчим хүчний яамны зүгээс гэрээ цуцалснаас үүдэн учирсан хохирлын нэхэмжлэлийг гүйцэтгэгчээс гаргуулахаар буюу дампуурлын хэрэгт өр, авлагын төлөвлөгөөнд нэхэмжлэлээ оруулахаар ЭКСИМ банкнаас сонгон шалгаруулсан "Lee&Ko" хуулийн фирмээр дамжуулан БНСУ-ын Сөүл хотын Дампуурлын шүүхэд хүсэлт гаргасан.

Түүнчлэн, гэрээ цуцалсантай холбогдуулан гүйцэтгэлийн баталгаа /5.5 сая ам.доллар/ болон урьдчилгаа төлбөрийн баталгаа /19.6 сая ам.доллар/-г Олон Улсын "URDG 758" дүрмийн дагуу албан ёсоор нэхэмжилсэн ба 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр гүйцэтгэлийн баталгааг шилжүүлсэн. Харин "Бьюксан инженеринг" компани нь урьдчилгаа төлбөрийн баталгааг БНСУ-ын Сөүл хотын шүүхэд хүсэлт гаргасны үндсэн дээр Сөүлийн төв дүүргийн шүүхээс "Урьдчилгаа төлбөрийн баталгааны төлбөр олголтод түр хориг тавих тухай" шийдвэрийг гаргаж, дээрх төлбөрийг шилжүүлээгүй байна.

Үүсээд байгаа асуудлаар Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан холбогдох яамдаас санал авч 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулаад байна. /Засгийн газрын тогтоолыг хавсаргав./

Асуулгын хариулт-1.

Өвөрхангай аймгийн төвийн дулааны станцын төсөлд хуваарилсан 18.7 тэрбум төгрөгийн санхүүжилт графикийн дагуу олгогдож байгаа эсэх, одоогийн байдлаар гүйцэтгэгч компанид шилжүүлсэн санхүүжилтийн талаарх тоон мэдээллийн тухайд:

Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Өвөрхангай/ гэсэн ажлын тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчээр шалгарсан "Энерго сервис монтаж" ХХК-тай 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр УТ2503001026 дугаартай гэрээг байгуулсан байна. Гэрээний дүн нь 18,740,064,688.0 төгрөг бөгөөд гэрээний хугацаа 2027 оны 08 дугаар сарын 30-ны өдөр дуусна.

Төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлын хувьд 2025-2026 онд хийгдэх материал татан авалт 100% хийгдсэн, 2025 онд хийгдсэн ажлуудын нөхөн сэргээлтийн ажил хийгдэж дууссан. Өнөөдрийн байдлаар нийт барилга угсралтын ажил 42%-ийн гүйцэтгэлтэй, 4 удаагийн гүйцэтгэлээр 7,623,973,137.0 төгрөгийн буюу 41 хувийн санхүүжилтийг олгоод байна.

Асуулгын хариулт-2.

Дулааны станцын барилга угсралтын ажлын төлөвлөгөө, 2026 оны 6 дугаар сарын байдлаарх гүйцэтгэл, ашиглалтад бүрэн орох бодит хугацаа, холбогдох тайлбарын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, салбарын яамнаас тавьж байгаа хяналт,

ажлын гүйцэтгэлд хууль тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцсон эсэх тухайд:

Төслийн барилга угсралтын ажил 2026 оны 06 дугаар сарын байдлаар 41,93%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан төслийг амжилттай хэрэгжүүлж дуусгахын тулд барилга угсралтын ажлын шинэчилсэн төсвийн хүрээнд төслийн санхүүжилтийг шийдвэрлэх хувилбаруудыг боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Засгийн газрын 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 291 дүгээр тогтоолоор Дулааны станц, шугам сүлжээний барилга угсралтын ажлыг 2028-2029 оны өвлийн оргил ачааллаас өмнө улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулах үүрэг даалгаврыг өгсөн.

Уг төслийг цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан шинэ гүйцэтгэгч сонгон шалгаруулахад холбогдох бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Төслийн ерөнхий гүйцэтгэгч төлбөрийн чадваргүй болж гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас төслийн барилга угсралтын ажил зогссонтой холбоотой үүссэн маргаануудыг хэлэлцээний замаар шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тул Засгийн газрын 2017 оны 160 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гадаадын арбитр болон гадаад улсын шүүхэд маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх, маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэх, маргаан үүссэн тохиолдолд баримтлах журам"-д заасны дагуу Монгол Улсын эрх ашгийг шүүхээр хамгаалуулах ажлыг яаралтай зохион байгуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Эрчим хүчний яам хамтран ажиллаж байна.

Асуулгын хариулт-3.

Арвайхээр сумын 5, 13 дугаар багийн уурын зуухнуудын хоёрдугаар хэлхээний шугам сүлжээг шинэчлэх 5.7 тэрбум төгрөгийн ажлын үр дүн, явцын тухайд:

"Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц /Өвөрхангай/" гэсэн төсөл арга хэмжээний хүрээнд дээрх ажлууд багтаж байгаа бөгөөд 2025 онд тус төсөл, арга хэмжээнд 5,700,000,000.0 төгрөг тусгагдсан. Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ /Гэрээний үнийн дүн 18,740,064,688.0 төгрөг/-ний дагуу 2025 онд батлагдсан санхүүжилтдээ тааруулан 5 дугаар баг /УДДТ9/-1,933,064,564.0 төгрөг, 13 дугаар баг /УДДТ5/-4,373,963,942.0 төгрөг, нийт 6,307,028,506.0 төгрөгийн 2 багц ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж, графикийн дагуу ажлаа гүйцэтгэж 2025 оны санхүүжилтээ бүрэн авсан.

Уг ажлын хүрээнд УДДТ5-1.51 км шугам, 26 ширхэг дулааны худаг ба УДДТ9-1.04 км шугам, 20 ширхэг худаг тус тус хийгдсэн. Тохижилт нөхөн сэргээлтийн ажлыг 2026 онд гүйцэтгэж байгаа бөгөөд трассын дагуу буулгасан мод, төмөр, бетон хашаа хайсыг бүрэн сэргээсэн. Авто зам сэтэлж гүйцэтгэсэн ажлын сэргээлтийг бүрэн гүйцэтгэсэн бөгөөд одоогоор явган замын нөхөн сэргээлтийн ажил 80%-тай үргэлжилж байна.